



Оюу Толгой ХХК

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны
удирдлагын тогтолцооны журам

Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх журам

Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E5-PRC-0002-M	Хувилбар: 1.0

1 ЗОРИЛГО

Энэхүү журамд аюултай бодис асгарсан тохиолдолд тухайн бодисын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах үүднээс үр дүнтэй шуурхай хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг тусгасан болно.

2 ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

Энэхүү журам нь Оюу Толгой ХХК-ийн буюу түүний өмнөөс бусад этгээдийн хариуцан ажиллуулж буй бүх ажлын байранд асгарсан бодисыг зохицуулахад хамаарна.

3 АЛБАН ТУШААЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Албан тушаал	Үүрэг хариуцлага
Байгаль орчны менежер	<ul style="list-style-type: none"> Удирдлагын зүгээс шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх, журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцөөр хангах Журмыг баталж, Оюу Толгойн нийт ажилчид, гэрээт гүйцэтгэгчдэд мэдээлэх Асгарсан бодист хяналт тавьж, тэдгээрийг аюулгүйжүүлэхэд авах арга хэмжээний талаар ажилчид, гэрээт гүйцэтгэгчдэд зөвлөгөө өгөх байгаль орчны мэргэшсэн ажилтнаар хангах.
Хэлтсийн менежерүүд	<ul style="list-style-type: none"> Удирдлагын зүгээс шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх, журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцөөр хангах Журмыг баталж, Оюу Толгойн нийт ажилчид, гэрээт гүйцэтгэгчдэд мэдээлэх Асгарсан бодист хяналт тавих, ажилчид, гэрээт гүйцэтгэгчид зөвлөгөө өгөх байгаль орчны мэргэжлийн шинжээч ажиллуулах
Ахлах мэргэжилтэн, Ахлах ажилтнууд	<ul style="list-style-type: none"> Өөрийн хариуцсан хэсэгт аливаа бодис асгарах явдлыг багасгах үүднээс зохих инженерийн болон үйл ажиллагааны хяналтыг бий болгох. Шаардлагатай ажилчдыг асгарсан бодисыг аюулгүйжүүлэх, түүнийг мэдээлэх сургалтад хамруулах.
Ахлах мэргэжилтэн болон Ахлах ажилтнууд	<ul style="list-style-type: none"> Өөрийн хариуцсан хэсэгт энэхүү журмын шаардлагыг хэрэгжүүлэх Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх талаар явагдаж буй сургалт болон мэдээлэл өгөх хуралд ажилчид, гэрээт гүйцэтгэгчдийг хамруулах
Химийн бодис, хог хаягдлын зохицуулагч	<ul style="list-style-type: none"> Бодис асгарахаас урьдчилан сэргийлэх, хянах, тархалтыг хязгаарлах, цэвэрлэх болон устгах талаар техникийн зөвлөгөө өгөх Аюултай материалыг устгах ажиллагаанаас гарсан бүх бохирдсон материалыг устгах/хаях ажлыг батлах
Ажилчид болон гэрээт гүйцэтгэгчид	<ul style="list-style-type: none"> Нүүрс-устөрөгч болон химийн бодис асгарсан бүх тохиолдлыг ахлах ажилтандаа мэдээлэх. Нүүрс-устөрөгч болон химийн бодис асгарсан тохиолдолд энэхүү журмын дагуу тодорхойлж, арга хэмжээ авах
Сургалтын менежер	<ul style="list-style-type: none"> Танилцуулах болон бусад сургалтын үеэр ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид шаардлагатай нүүрс-устөрөгч, химийн бодисын сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох

Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е5-PRC-0002-М	Хувилбар: 1.0

4 ЖУРАМ

4.1 Ерөнхий шаардлага

- Ажилчид болон гэрээт гүйцэтгэгчид бодис асгарсан бүх тохиолдлыг ахлах ажилтандаа амаар нэн даруй мэдэгдэх үүрэгтэй;
- Ахлах ажилтнууд асгарсан бодисын талаар авах арга хэмжээг зохион байгуулж, тэдгээрийг *Проспектод* байгаль орчны осол гэж бүртгэнэ. Энэхүү ажлыг Оюу Толгой компанийн ЭМААБО-ы удирдлагын системийн Ослын менежмент, шалган судлах, баримтжуулах, хяналт тавих журмын дагуу гүйцэтгэнэ;

4.2 Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх хэрэгсэл

- Ахлах ажилчид асгарсан бодисыг аюулгүйжүүлэх багаж хэрэгслийг сайтар тэмдэглэсэн байх шаардлагатай ба бодис асгарсан тохиолдолд цаг алдалгүй ашиглах боломжтой газар байршуулсан байна.
- Бүх ажлын хэсэгт байх асгарсан бодисыг аюулгүйжүүлэх багаж хэрэгсэлд дараах тоног төхөөрөмжүүд байна. Үүнд:
 - Хүрз;
 - 2 хагааржуулах баг;
 - Шингээгч материал (дөрвөлжин буюу гонзгой шингээгч);
 - 2 х нүдний шил;
 - 1 х 60 литрийн багтаамжтай битүү тагтай сав;
 - 2 х хамгаалалтын резинэн бээлий;
 - 1 х шингээгч бодис;
 - 1 х дугуйтай улаан хогийн сав;
- Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх багаж хэрэгслийг их хэмжээний бодис асгарах өндөр эрсдэлтэй нь тогтоогдсон хөдөлгөөнт тоног төхөөрөмжид байнга авч явна. Энэхүү багаж хэрэгсэлд байгаа зүйлс нь тухайн хөдөлгөөнт тоног төхөөрөмжөөс үүсэх эрсдэлд хэрэглэхэд тохирсон байх шаардлагатай ба тээвэрлэж буй материалд мөн адил тохиромжтой, хүрэлцэхүйц хэмжээтэй байна;
- Засварын цех болон аюултай материал хадгалах зориулалт бүхий талбайн (жишээ нь: ил уурхайн ам, хүдэр тээвэрлэх зам, зогсоол) ойр орчимд бодис асгарах өндөр эрсдэлтэй тохиолдолд тухайн үүсэх эрсдэлд тохирох аюулгүйжүүлэх тоног төхөөрөмжтэй байна.

4.3 Аюултай бодис асгарахад тавих хяналт

- Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх арга хэмжээ авахаас өмнө ажилчид, гэрээт гүйцэтгэгчид болон хөндлөнгийн ажиглагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэн түрүүнд хангана;
- Бодис асгарсан үед эрсдэлд орж болзошгүй байгаа ажилтныг тухайн ажлын хэсгийг хариуцаж буй ахлах ажилтан болон ахлах мэргэжилтэн уг газраас холдуулах үүрэгтэй;
- Бодис асгарснаас үүдэн хөндлөнгийн хүмүүс эсвэл байгаль орчинд гэнэтийн аюул учирч болзошгүй тохиолдолд (жишээ нь: гал гарах, дэлбэрэх, гүний ус

Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E5-PRC-0002-M	Хувилбар: 1.0

бохирдох гэх зэрэг) тухайн эрсдлийг тогтоосон ажилтан төслийн талбай дахь онцгой байдлын багт нэн даруй мэдэгдэнэ;

- d) Тухайн нөхцөл байдлыг аюулгүй гэж үзвэл, бэлтгэгдсэн ажилтан асгарсан бодисыг эх үүсвэрт нь тогтоох арга хэмжээ авч, дулаан болон гал авалцах бүх эх үүсвэрийг салгах оролдлого хийнэ /жишээ нь: гоожиж байгаа клапаныг хааж, хөмөрсөн цилиндрийг босгож тавих, хагарсан шингэний хоолойг тусгаарлах г.м/;
- e) Дараа нь тухайн асгарсан бодисын талаар ахлах ажилтандаа амаар нэн даруй мэдэгдэж, Ахлах ажилтан тухайн асгарсан бодисыг хязгаарлаж, цэвэрлэх ажиллагааг зохион байгуулна;
- f)
- g) Ахлах мэргэжилтэн болон ахлах ажилчид Байгаль орчны хэлтсийг асгарсан бодисын талаарх дэлгэрэнгүй мэдээллээр хангаж, заавар зөвлөмж авч, хуулийн дагуу мэдээлэх үйл ажиллагааг эхлүүлнэ.

4.4 Нүүрс-устөрөгчийн тархалтыг хязгаарлах ба цэвэрлэх

- a) Асгарсан бодисын тархалтыг тухайн асгарсан талбайг тойруулан шингээгч материал /гозгой шингээгч ашиглах ба хэрэв засварын цех болон зориулалтын агуулахын ойр орчимд бол шороон далан байгуулан тус тус хязгаарлана;
- b) Хязгаарлалт хийсний дараа илүү гарсан нүүрс-устөрөгчийг шингээгч материалд (шороо г.м) шингээн авах ба хэрвээ тухайн асгарсан бодис нь дангаараа аль эсвэл усан дээр хөвж байгаа тохиолдолд сорогч машин ашиглан соруулж авна;
- c) Нүүрс-устөрөгчийг ус зайлуулах хоолой болон усны сувагт нэвтрэхээс урьдчилан сэргийлнэ. Хэрэв нүүрс-устөрөгч ус зайлуулах хоолой болон усны сувагт нэвтэрсэн бол тэдгээрийг далангаар хашиж буюу хөвөгч хүрээгээр тусгаарлаж тархалтыг нь багасгана;
- d) Хаягдал материалыг зохих журмын дагуу устгана. Бохирдсон шингээгч бодис, шингээгч хүрээ, дэр, дэвсгэр зэргийг зориулалтын хогийн саванд хийнэ. Бохирдсон шороо болон усыг Химийн бодис, хог хаягдлын зохицуулагчийн зааврын дагуу зайлуулж, зориулалтын газар хадгалана.

4.5 Бохир усны тархалтыг хязгаарлах ба цэвэрлэх

- a) Асгарсан бохир усыг урсгал ус болон ус зайлуулах шугамд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх үүднээс элс, шороогоор тогтооно;
- b) Ажилчдын зам дээр байгаа бохир ус асгарсан талбайг тойруулан гипохлорид кальцийн нунтаг цацаж өгнө. Бохир ус нь урсгал ус болон ус зайлуулах системд нэвтэрсэн тохиолдолд гипохлорид кальцийн нунтагаар ариутгана;
- c) Бохир усыг сорогч машинаар шавхаж ус цэвэршүүлэх байгууламжид хүргэнэ. Үлдсэн бохир ус болон хатуу хог хаягдлыг гипохлорид кальцийн нунтаг ашиглан ариутгана.

4.6 Аммонийн нитратын тархалтыг хязгаарлах ба цэвэрлэх

- a) Асгарсан бодисын тархалтыг элс, шороо гэх зэрэг шингээгч материал ашиглан хязгаарлах бөгөөд ингэхдээ тоос шороо босгохоос зайлсхийнэ.
- b) Шингэн болон хатуу хог хаягдлыг сайтар тэмдэглэгээ хийгдсэн лацтай саванд хийж дахин боловсруулна. Цэвэрлэх боломжгүй үлдэгдэл гарсан тохиолдолд Уурхайн тэсэлгээний төлөөлөгчид хандаж устгуулна.

Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е5-PRC-0002-М	Хувилбар: 1.0

4.7 Химийн бодисын тархалтыг хязгаарлах ба цэвэрлэх

- Асгарсан бодисыг урсгал ус болон ус зайлуулах хоолойд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх үүднээс тэдгээрийн тархалтыг элс, шороо, модны үртэс болон бусад химийн идэвхгүй материал ашиглан хязгаарлана;
- Химийн бодисын төрлөөс хамааран цэвэрлэх аргачлал нь харилцан адилгүй байна. Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх ердийн зориулалттай шингээгч хэрэгслийг (тос шингээгчийн оронд) ашиглана. Цэвэрлэх боломжтой бүтээгдэхүүнийг цуглуулж Хог хаягдал, Химийн бодисын зохицуулагчийн зааврын дагуу зориулалтын хог хаягдлын цэг, байгууламжид устгана.

4.8 Баяжуулах үйлдвэрийн хаягдал усны тархалтыг хязгаарлах ба цэвэрлэх

- Умбуур бодисын хэмжээ бага байгаа тохиолдолд асгарсан бодисын тархалтыг хязгаарлахгүйгээр өөрөөр нь ууршуулна.
- Умбуур бодисын хэмжээ өндөр буюу ургамлан бүрхэвч, урсгал усыг бохирдуулах эрсдэлтэй бол илүүдэл усаар угааж зайлуулна.

4.9 Аккумуляторын хүчлийн тархалтыг хязгаарлах ба цэвэрлэх

- Асгарсан бодисын тархалтыг тогтоож, Хог хаягдал, химийн бодисын зохицуулагчийн зөвлөмжийн дагуу сод зэрэг энгийн бодисоор саармагжуулна;
- Цэвэрлэх боломжтой бүтээгдэхүүнийг цуглуулж Хог хаягдал, химийн бодисын зохицуулагчийн зөвлөмжийн дагуу содоор саармагжуулах;
- Үйлдвэрийн хаягдал устай хамт зайлуулах.

4.10 Бохирдсон материалыг устгах

- Ослын тайланд асгарсан бодисыг өндөр эрсдэлтэй гэсэн ангилалд хамруулсан тохиолдолд цэвэрлэгээний ажлын чанарыг дүгнэхдээ цэвэрлэгээний дараа бохирдсон талбайгаас дээж авч Монгол улсад мөрдөгдөж буй агаар, ус болон хөрсний бохирдлын зөвшөөрөгдөх дээд хэмжээний стандарттай харьцуулж үзнэ.
- Дээжид агуулагдаж буй бохирдуулагч бодисын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд цэвэрлэгээний ажлыг хангалтгүй гэж үзээд нэмэлт цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэнэ.
- Байгаль орчны байцаагчид мэдэгдэх шаардлагатай тохиолдол бүрт цэвэрлэгээний ажлын дараа нэмэлт дээж авалт хийнэ.
- Нүүрс-устөрөгчөөр бохирдсон хөрсийг ухаж авах бөгөөд зориулалтын газар хадгалж цэвэрлэнэ.

4.11 Мэдээлэх

- Одоо мөрдөгдөж буй хууль журамд эрх бүхий байгууллагад мэдэгдвэл зохих бодис асгарсан тохиолдлын талаар заалт байхгүй ч Байгаль орчны хэлтэс нь аливаа асгарсан бодис дор заасан хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд Байгаль орчны улсын байцаагчид мэдэгдэнэ:

Бохир ус: $\geq 100 \text{ м}^3$;

Ус: $\geq 1,000 \text{ м}^3$;

Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е5-PRC-0002-М	Хувилбар: 1.0

Нүүрс-устөрөгч: $\geq 10 \text{ м}^3$;

Хог хаягдал: $\geq 1,000 \text{ м}^3$;

Мөн Байгаль орчны улсын байцаагчийн шаардлага тавьсан бусад химийн бодис;

- b) Проспектод бүртгэгдсэн бодис асгарсан тохиолдол бүрийг шалгаж, арга хэмжээ авна.

4.12 Сургалт

- a) Сургалт хариуцсан менежерийн тодорхойлсны дагуу шаардлагатай ажилчид болон гэрээт гүйцэтгэгч нарыг хорт бодистой харьцах болон асгарсан бодисыг аюулгүйжүүлэх сургалтанд хамруулсан байх;
- b) Химийн бодистой харьцдаг буюу химийн бодисын агуулах болон үйл ажиллагааны хэсэгт ажилладаг ажилчид бүх төрлийн химийн бодисын Хор аюулын лавлах мэдээллийг авч ашиглах боломжтой байх;
- c) Химийн бодис, хаягдлын зохицуулагч нь асгарсан бодисыг аюулгүйжүүлэх талаар зөвлөгөө, туслалцаа үзүүлнэ.

5 ТОДОРХОЙЛОЛТУУД

Бодис асгарах: Байгаль орчинд сөрөг нөлөө бүхий химийн бодис хүрээлэн буй орчинд ямар нэгэн хэмжээгээр асгарах буюу гоожих. Жишээ нь: авто грейдерээс дизель гоожих, усны хоолой задрах гэх мэт.

Хашлага: Хүрээлэн буй орчинд бодис асгарч тархахаас сэргийлэх, тогтоох болон бодис асгарсан тохиолдолд түүнийг эргүүлэн авах, цэвэрлэх боломж олгох зориулалттай хаалт, хашилт.

Нэмэлт хаалт: Асгарсан буюу гоожсон бодисыг тогтоох, хязгаарлах нэмэлт арга хэмжээ. Жишээ нь: нэмэлт хашлага, давхар ханатай хоолой буюу сав/цистерн.

Ус зайлуулах суваг: Усны хиймэл гольдрил, борооны ус зайлуулах суваг эсвэл хүний гараар байгуулсан гуу жалга.

Нүүрс-устөрөгч: Оюу Толгой төслийн хүрээнд ашиглагдаж буй дизель түлш, бензин болон төрөл бүрийн тос, тосолгооны материал.

Шингээгч: Асгарсан буюу гоожсон бодисыг тогтооход ашигладаг синтетик болон органик шингээгч, хүрээ, нунтаг бодис. Эдгээр нь төрөл бүрийн хэлбэр, зориулалттай байна.

Хор аюулын лавлах мэдээлэл (ХАЛМ): Хэрэглэгч, худалдан авагчдыг тухайн бодисын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хор хөнөөл, аюулгүй ажиллагааны сэрэмжлүүлэг, хадгалалт, устгалтай холбоотой мэдээллээр хангах зориулалттай, үйлдвэрлэгчээс гаргасан баримт бичиг.

Enso**rb**TM: Асгарсан бодисыг аюулгүй болгоход ашиглагддаг шингээгч материал юм. Enso**rb**TM нь бүх төрлийн шингэнийг шингээх чадвартай.

Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E5-PRC-0002-M	Хувилбар: 1.0

6 ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГҮҮД

	Нэр	Байршил
Хууль эрх зүйн болон бусад шаардлагууд	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам. 2009.02.03	Хууль эрхзүйн бичиг баримтын бүртгэлийн сан
	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага.	
	MNS 4585:1998 Усны чанар. Техникийн ерөнхий шаардлага.	
	MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрсийг бохирдуулагч бодис болон элементүүд	
Оюу Толгой компанийн ЭМААБО-ы менежментийн систем	ОТ ЭМААБО-ы удирдлагын системийн Зөрчил, осол, хариу арга хэмжээний менежментийн журам	ОТ портал
	ОТ ЭМААБО-ы удирдлагын системийн Эрсдэлтэй тохиолдлын менежмент, шалган судлах, баримтжуулах болон хянах журам	
	ОТ Ослын менежментийн дарааллын схем	
	Оюу Толгой компанийн ЭМААБО-ы менежментийн системийн Сургалт болон мэдээллийн журам	
Харилцаа холбоо/ Сургалт	Аюултай материал болон бохирдлыг хянах сургалт	ОТ портал

6.1 Бусад шаардлагууд

Аюултай материал болон бохирдлын хяналт (2008 он) буюу E5 стандарт нь Рио Тинто компанийн аюултай материалын менежментийн үндсэн стандарт юм. Бусад холбогдох баримт бичгийн тоонд дараах стандартууд орно:

- B4 Аюултай бодисын стандарт (Хөдөлмөрийн эрүүл мэнд);
- E2 Агаарын чанарын хяналтын стандарт;
- E9 Газар ашиглалтын хариуцлагын стандарт;
- E10 Усны хэрэглээ, чанарын хяналтын стандарт;
- ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага (2008) (нэн ялангуяа PR1: Байгаль орчин, нийгмийн үнэлгээ болон менежмент PR3: Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх ба бууруулах);
- ОУСК-ийн Уул уурхайн БОЭМАА-ны журам, 2007 он;
- ОУСК-ийн БОЭМАА-ны ерөнхий журам, 2007 он.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е5-PRC-0002-М	Хувилбар: 1.0

7 БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

Файлын нэр	ОТ-10-Е5-PRC-0002-М-Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх журам
Тайлбар	Байгаль орчинд асгарсан бодисыг аюулгүйжүүлэх журам
Эх зохиогч	Санжмятавын Мөнгөнчимэг, Баасансүрэнгийн Долгор
Боловсруулсан огноо	2012.06.25
Баталсан	Марк Ньюби, Байгаль орчны асуудал хариуцсан менежер
Баталсан огноо	2013.05.06
Өөрчлөлт хийсэн бүртгэлийн дугаар	##

Эрсдлийн зэрэглэл	Үнэлгээ хийсэн огноо	Эрсдлийг үнэлсэн	Засвар өөрчлөлт оруулах хуваарь	Дараагийн хяналт хийх огноо
Дунд зэрэг	2012.07.10	Баасансүрэнгийн Долгор	2 жил тутам	2015.05.06

Хувилбар	Засвар өөрчлөлт хийсэн огноо	Эх зохиогч	Баталсан	Хяналт хийсэн тэмдэглэл
1.0	2013.05.06	Санжмятавын Мөнгөнчимэг, Баасансүрэнгийн Долгор	Марк Ньюби	Батллагдсан хувилбар